



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хууль тогтоомж мөрдөөгүй, ТАХ-ний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг дутуу хэрэгжүүлсэн, хөрөнгө оруулалтын ажлууд чанарын болон ашиглалтын шаардлага хангаагүй зөрчил илэрч байна.



АУДИТЫН СЭДЭВ: ДҮҮРГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Улаанбаатар хот
2025 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2.4, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Дүүргийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2025/06-11-ШТА-ГА) тайлан, акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт зөвлөсүгэй.

3.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2025 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4.Тайланг дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Нийслэл дэх Төрийн аудитын газар	Товчилсон үг	3
Дэд дарга  Ч.Болд	Хүснэгтийн жагсаалт	4
Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга	Хавсралтын жагсаалт	4
 Э.Мөнхмандах		
Аудитын менежер  Л.Саранбаатар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5
Ахлах аудитор  С.Анужин	Ерөнхий мэдээлэл	6
Аудитор  О.Оргил	А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх	7-9
 Д.Эрдэнэбулган	А.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн, холбогдох зардлын тооцоолол хийсэн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?	7
	А.2. Төсөвлөлтийн шаардлага хангасан, эдийн засаг нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлсэн төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?	8-9
	Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан эсэх	10-23
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 11-327787	Б.1. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, хууль журмын хүрээнд шалгаруулсан уу?	10-14
Тайланг НТАГ-ын http://www.audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	Б.2. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь, холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хяналт хэрэгжүүлж, хүлээн авсан уу?	15-23
	В. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэж, хөрөнгө бүртгэлд тусгасан эсэх	24-28
	В.1. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан уу?	24
	В.2 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон уу?	24-26
	В.3 Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авч, өмчийн бүртгэлд тусгасан уу?	26
	Аудитын дүгнэлт	27
	Аудитын зөвлөмж	28
	Холбогдох байгууллагын санал	29-31
	Саналд өгсөн тайлбар	32
	Хавсралтууд	33-45

ТОВЧИЛСОН ҮГ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ДИТХ	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ДЗД	Дүүргийн Засаг дарга
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТА	Инженер техникийн ажилтан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НД	Налайх дүүрэг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЗХГ	Нийслэлийн замын хөгжлийн газар
НХОГ	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн Аудитын газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТГУХ	Төлөвлөлт, гүйцэтгэл удирдлагын хэлтэс
ТНААХ	Тохжилт, нийтийн аж ахуйн хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн судалгаа	7
Хүснэгт 2	Зардлын тооцоолол хийгээгүй ТАХ	7
Хүснэгт 3	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ	8
Хүснэгт 4	Дүүргүүдийн 2024 онд хэрэгжүүлэх ТАХ-ний ангилал	9
Хүснэгт 5	Худалдан авах ажиллагааны явц	10
Хүснэгт 6	Тайлант онд хэрэгжээгүй ТАХ	10
Хүснэгт 7	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан арга	11
Хүснэгт 8	ХАА зохион байгуулахтай холбоотой илэрсэн зөрчил	11
Хүснэгт 9	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт	15
Хүснэгт 10	Түүвэрт хамрагдсан ТАХ-нд илэрсэн зөрчил	15
Хүснэгт 11	ТАХ-ний санхүүжилтийн судалгаа	24
Хүснэгт 12	2024 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт, барьцаа, алданги	24-25
Хүснэгт 13	Гэрээний алданги дутуу тооцсон ТАХ	25
Хүснэгт 14	Урьдчилгаа төлбөрт илүү олгосон санхүүжилт	25
Хүснэгт 15	Хөрөнгө бүртгэлийн нэгтгэл	26

Хавсралтын жагсаалт


Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгаагүй ТАХ	33-34
Хавсралт 2	ДЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй ТАХ	35-36
Хавсралт 3	Холбогдох зардлын тооцоолол хийгээгүй ТАХ	36-37
Хавсралт 4	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ	37-42
Хавсралт 5	Хэрэгжээгүй ТАХ	43-44
Хавсралт 6	ТАХ-г хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилаагүй ТАХ	44-45

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалаар баталсан Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Аудитын зорилт: Дүүргийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✚ Хөрөнгө оруулалтын ТАХ-г холбогдох хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх; ✚ Хөрөнгө оруулалтын ТАХ-г хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан эсэх; ✚ Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний санхүүжилтийг шийдвэрлэж, хөрөнгө бүртгэлд тусгасан эсэх.
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт, худалдан авалт, санхүүжилт, хэрэгжилт, холбогдох баримт материал, мэдээлэл судалгааг хамруулан аудитыг хийж гүйцэтгэсэн.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг АДБОУС 100, 300, 3000-3100, Төрийн аудитын стандарт MNS 6817:2020, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, нөхцөл байдлын шинжилгээ хийх, газар дээр нь тулган баталгаажуулж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор С.Анужин, аудитор О.Оргил, Д.Эрдэнэбулган нар гүйцэтгэв.</p>

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 640,286.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 839 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан. Үүний 421,380.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 612 нь шинээр хэрэгжих, 218,906.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 227 нь өмнөх оноос дамжин хэрэгжиж буй ТАХ байна.

Дүрслэл 1. Нийт төсөл арга хэмжээний ангилал



Дүүргийн ЗД нар худалдан авах ажиллагааг зохион байгуулах захирамж гаргахдаа дээрх 612 ТАХ-г нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан 718 ТАХ болгон хуваажээ.

Үүнээс 2024 онд 346,143.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 615 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан, 22,558.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 61 ТАХ-ний худалдан авалтыг зохион байгуулж дуусаагүй, 39,972.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 ТАХ хэрэгжээгүй байна.

Өмнөх онуудад болон 2024 онд шинээр гэрээ байгуулсан 522,256.7 сая төгрөгийн 822 ТАХ-ээс 223,260.5 сая төгрөгийн дүнтэй 578 ТАХ бүрэн хэрэгжсэн, 255,198.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 154 ТАХ хэрэгжиж байгаа, 43,798.2 сая төгрөгийн 90 ТАХ хэрэгжээгүй байна.

Дээрх 839 ТАХ-нд 2024 онд 463,170.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоос, гүйцэтгэлээр 662 ТАХ-нд 305,871.1 сая төгрөг буюу 66.0 хувийг нь олгожээ.

Аудитын түүврийг хийхдээ МУЕА-ын 2018 оны А/351 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу эх олонлогийг бүхэлд нь хамруулах үүднээс 2024 онд хэрэгжсэн ТАХ-ний төсөвт өртөг болон төрөл тус бүрээс хамруулсан. Үүнд:

- Төлөвлөлт: 2024 онд шинээр төлөвлөсөн 421,380.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 612 ТАХ-г бүрэн;
- Худалдан авалт зохион байгуулсан 615 ТАХ-ээс 287,604.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 292 ТАХ буюу 47.5 хувийг;
- Гэрээний хэрэгжилт: 2024 онд бүрэн дууссан, санхүүжилт олгосон 223,260.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 578 ТАХ-ээс 291 буюу 50.3 хувийг;
- Санхүүжилт: Шинээр болон он дамжин хэрэгжсэн 662 ТАХ-нд олгосон 305,871.1 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн хамруулсан.

БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХОЛБОГДОХ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН ЭСЭХ

А.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн, холбогдох зардлын тооцоолол хийсэн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн эсэх:

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 612 ТАХ-г хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн эсэхийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д 549 ТАХ буюу 89.7 хувь нь нийцсэн, 63 ТАХ буюу 10.3 хувь нь нийцээгүй;
- “ДЗД-ын тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 569 ТАХ буюу 93.0 хувь нь нийцсэн, 43 ТАХ буюу 7.0 хувь нь тус тус нийцээгүй байна. (Хавсралт 1, 2)

Хүснэгт 1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн судалгаа

№	Дүүргийн нэр	ТАХ-ний тоо	Үүнээс			
			Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд		ДЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд	
			Нийцсэн	Нийцээгүй	Нийцсэн	Нийцээгүй
1	СБД	117	117	-	117	-
2	ХУД	112	110	2	108	4
3	БГД	78	78	-	78	-
4	СХД	77	62	15	60	17
5	ЧД	73	73	-	73	-
6	БЗД	69	52	17	51	18
7	БНД	45	16	29	41	4
8	НД	27	27	-	27	-
9	БХД	14	14	-	14	-
НИЙТ		612	549	63	569	43

Холбогдох зардлын тооцоолол хийсэн эсэх:

Төсвийн тухай хуулийн 29.2-т “Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна” гэж заасан.

Дүүргүүдийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжих 612 ТАХ-ээс барилга байгууламжийн ангилалд хамаарах 37 ТАХ-нд зардлын тооцоолол хийхээр байгаа ч хийгдээгүй байна. Хавсралт 3

Хүснэгт 2. Зардлын тооцоолол хийгээгүй ТАХ

№	Дүүрэг	Ангилал: Барилга байгууламж	
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг (сая.төг)
1	СБД	12	52,329.1
2	ХУД	11	42,647.0
3	БГД	4	17,244.1
4	СХД	5	5,802.3
5	ЧД	1	4,900.0
6	БЗД	2	4,784.4
7	БНД	1	250.0
8	НД	1	12.0
НИЙТ		37	127,968.9

Дүгнэлт: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд шинээр хэрэгжих ТАХ-ний 91.3 хувь нь нийцсэн хэдий ч хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцоолол, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт гаргаагүй байна.

А.2. Төсөвлөлтийн шаардлага хангасан, эдийн засаг нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлсэн төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх 612 ТАХ-ээс 339,390.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 389 ТАХ буюу 63.6 хувьд нь зураг төсөв шаардлагатай байна. Үүнээс төсөвлөлтийн шаардлага хангаагүй 217,927.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 237 ТАХ байна. Үүнд:

- Ажлын даалгаваргүй 7.6 хувь буюу 18 ТАХ;
- Зураг төсөвгүй 28.2 хувь буюу 67 ТАХ;
- Магадлалын ерөнхий дүгнэлтгүй 22.8 хувь буюу 54 ТАХ;
- Төсөв баталсны дараа магадлалын ерөнхий дүгнэлт гарсан 41.4 хувь буюу 98 ТАХ

Хавсралт 4

Хүснэгт 3. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ

(сая.төг)

№	Дүүргийн нэр	Зураг төсөв шаардлагатай ТАХ		Ажлын даалгаваргүй		Зураг төсөвгүй ТАХ		Магадлалын ерөнхий дүгнэлтгүй		Төсөв баталсны дараа магадлалын дүгнэлт гарсан		Нийт	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	ХУД	74	96,428.9	-	-	32	20,157.4	16	42,485.0	12	22,906.1	60	85,548.5
2	БЗД	54	56,912.9	-	-	-	-	10	5,849.2	39	45,255.0	49	51,104.2
3	БГД	51	37,627.3	-	-	35	17,523.2	14	15,097.0	-	-	49	32,620.2
4	СБД	104	99,972.6	2	6,300.0	-	-	8	6,668.6	11	17,161.3	21	30,129.8
5	СХД	65	31,376.2	2	330.5	-	-	2	3,150.0	28	8,318.5	32	11,799.0
6	ЧД	21	10,550.5	13	4,199.9	-	-	-	-	-	-	13	4,199.9
7	БНД	12	4,600.3	-	-	-	-	-	-	8	2,175.2	8	2,175.2
8	НД	6	1,512.0	1	300.0	-	-	4	50.7	-	-	5	350.7
9	БХД	2	409.4	-	-	-	-	-	-	-	-	-	-
НИЙТ		389	339,390.1	18	11,130.4	67	37,680.6	54	73,300.4	98	95,816.1	237	217,927.5

ТАХ-ний эрэмбэ дарааллыг харгалзсан эсэх:

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4¹, 4.5², 5 дугаар зүйлийн 5.10³-д заасны дагуу ТАХ-г эрэмбэлэхдээ өмнөх оноос хэрэгжсэн ТАХ, их засвар, шинээр хэрэгжүүлэх ТАХ гэсэн дарааллаар, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх чиглэлийн төслүүд байх гэсэн үзүүлэлтийг харгалздаг байна.

Дүүргүүдийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжсэн ТАХ авч үзэхэд дараах байдлаар дараалалд оруулсан байна. Үүнд:

- Өмнөх онуудаас хэрэгжиж буй 218,906.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 227 ТАХ;
- Шинээр хэрэгжүүлэх 421,380.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 612 ТАХ байна.

¹ 4.4 Төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална. Үүнд:..4.4.1 шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл

4.4.2 Их засварын төсөл

4.4.3 Шинээр хэрэгжүүлэх төсөл

² 4.5 Төсөл нь холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

³ 5.10. Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар нь төсөвт тусгах хөрөнгө оруулалтын төслийг тодорхойлж, шийдвэрлэхдээ энэхүү журмын 4.4-т заасан эрэмбийг баримтлах үүрэгтэй;

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г иргэдийн амьдрал, өдөр тутмын хэрэгцээ шаардлагад үндэслэн хороодын барилга, эмнэлэг, автозам, тохижилт, ногоон байгууламж зэргээр эрэмбэлсэн байна.

Хүснэгт 4. Дүүргүүдийн 2024 онд хэрэгжүүлэх ТАХ-ний ангилал

Д/Д	Дүүргийн нэр	ТАХ	Барилга байгууламж	Авто зам, Дэд бүтэц	Их засвар, Тохижилт	Зураг төсөв, бусад	Тоног төхөөрөмж	Нийт
1	БГД	шинэ	4	2	45	4	23	78
		шилжих	1	1	12	1	3	18
2	БЗД	шинэ	5	17	32	1	14	69
		шилжих	2	26	20	4	-	52
3	БНД	шинэ	2	2	8	12	21	45
		шилжих	1	-	4	10	11	26
4	БХД	шинэ	1	1	-	9	3	14
		шилжих	-	-	-	1	-	1
5	НД	шинэ	2	3	6	-	16	27
		шилжих	1	1	-	1	-	3
6	СБД	шинэ	21	15	68	2	11	117
		шилжих	10	1	9	2	2	24
7	СХД	шинэ	11	20	34	2	10	77
		шилжих	8	5	1	4	1	19
8	ХУД	шинэ	12	26	36	18	20	112
		шилжих	10	10	13	18	5	56
9	ЧД	шинэ	3	4	14	36	16	73
		шилжих	6	1	3	11	7	28
НИЙТ		шинэ	61	90	243	84	134	612
		шилжих	39	45	62	52	29	227
		Дүн	100	135	305	136	163	839

Цаашид Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г батлахгүй байх шаардлагатай байна.

Дүгнэлт: Шинээр хэрэгжих зураг төсөв шаардлагатай 389 төсөл арга хэмжээний 60.9 хувь буюу 237 нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГҮҮЛЖ, ХҮЛЭЭН АВСАН ЭСЭХ

Б.1. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, хууль журмын хүрээнд шалгаруулсан уу?

ДИТХ-ын Төсөв батлах тухай тогтоолуудаар 2024 онд 421,380.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 612 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр баталсан.

ДЗД нар худалдан авах ажиллагааг зохион байгуулах захирамж гаргахдаа дээрх 612 ТАХ-г нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан 718 ТАХ болгон хуваажээ.

Үүнээс 2024 онд 408,674.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 718 ТАХ-ний ХАА-г зохион байгуулан 346,143.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 615 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 333,574.4 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 5. Худалдан авах ажиллагааны явц

(сая.төг)

№	Дүүргийн нэр	ХАА зохион байгуулсан		Үүнээс						
				Гэрээ байгуулсан			ХАА үргэлжилж байгаа		Хүчингүй болсон, хөрөнгө татагдсан	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Гэрээ дүн	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	СБД	185	115,637.0	158	80,881.6	78,265.2	21	8,170.4	6	26,585.0
2	ХУД	134	113,515.0	116	105,873.0	100,960.6	13	5,972.0	5	1,670.0
3	БЗД	75	68,351.6	75	68,351.6	67,945.2		-		-
4	БГД	79	47,069.9	69	39,759.9	37,434.6	5	1,445.0	5	5,865.0
5	СХД	79	35,661.7	66	28,385.9	26,504.5	3	3,282.4	10	3,993.4
6	ЧД	80	17,480.2	54	12,905.6	12,728.2	14	3,229.3	12	1,345.3
7	БНД	45	7,624.3	38	6,951.6	6,751.7	5	459.7	2	213.0
8	НД	27	2,335.5	26	2,035.5	2,021.4		-	1	300.0
9	БХД	14	999.4	13	998.9	962.9		-	1	0.5
НИЙТ		718	408,674.5	615	346,143.5	333,574.4	61	22,558.8	42	39,972.2

Дээрх ТАХ-ээс 22,558.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 61 ТАХ-ний худалдан авах ажиллагаа нь 2024 онд бүрэн дуусаагүй, 39,972.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 ТАХ нь төсвийн тодотголоор хөрөнгө нь татагдсан байна. (Хавсралт 5)

Хүснэгт 6. Тайлант онд хэрэгжээгүй ТАХ

(сая.төг)

№	Дүүргийн нэр	Нийт		Ажлын даалгаваргүй		Техникийн тодорхойлолтгүй	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	СБД	6	26,585.0	6	26,585.0		
2	БГД	5	5,865.0	2	700.0	3	5,165.0
3	СХД	10	3,993.4	10	3,993.4		
4	ХУД	5	1,670.0	5	1,670.0		
5	ЧД	12	1,345.3	12	1,345.3		
6	НД	1	300.0	1	300.0		
7	БНД	2	213.0	1	200.0	1	13.0
8	БХД	1	0.5	1	0.5		
НИЙТ		42	39,972.2	38	34,794.2	4	5,178.0

ХАА зохион байгуулсан ТАХ-ний худалдан авалтын 68.1 хувь буюу 419 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалт, 21.6 хувь буюу 133 ТАХ-г харьцуулалт, 9.3 хувь 57 ТАХ-г гэрээ шууд байгуулах, 0.8 хувь 5 ТАХ-г ерөнхий гэрээ, 0.2 хувь буюу 1 ТАХ-г нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар тус тус зохион байгуулжээ.

Хүснэгт 7. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан арга

(сая.төг)

№	Дүүргийн нэр	Гүйцэтгэгч сонгон шалгарсан		Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын арга		Гэрээ шууд байгуулах арга		Ерөнхий гэрээ		Нэг эх үүсвэрээс худалдан авах арга	
		Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ
1	ХУД	116	100,960.6	103	99,361.2	12	879.4	-	-	-	-	1	720.0
2	СБД	158	78,265.2	120	75,368.5	37	2,468.7	1	428.0	-	-	-	-
3	БЗД	75	67,945.2	67	67,380.7	8	564.6	-	-	-	-	-	-
4	БГД	69	37,434.6	45	34,954.9	20	2,024.1	2	29.9	2	425.8	-	-
5	СХД	66	26,504.5	38	24,119.7	25	2,169.2	3	215.7	-	-	-	-
6	ЧД	54	12,728.2	19	9,905.2	16	908.6	16	202.4	3	1,712.0	-	-
7	БНД	38	6,751.7	17	5,731.4	14	890.8	7	129.5	-	-	-	-
8	НД	26	2,021.4	4	1,625.9	1	67.0	21	328.5	-	-	-	-
9	БХД	13	962.9	6	909.8	-	-	7	53.1	-	-	-	-
НИЙТ		615	333,574.4	419	319,357.3	133	9,972.3	57	1,387.1	5	2,137.8	1	720.0

ХАА-ны ил тод байдлыг хангах хүрээнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1-т заасны дагуу ТАХ-ний ХАА-г Төрийн Худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулсан байна.

Тайлант онд ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан 333,574.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 615 ХАА-аас 284,537.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 292 ХАА буюу 47.5 хувийг аудитын түүвэрт хамруулан шалгасан. Үүнээс 11.6 хувь буюу 34 ТАХ-ны ХАА-нд зөрчил илэрсэн.

Хүснэгт 8. ХАА зохион байгуулахтай холбоотой илэрсэн зөрчил

(сая.төг)

№	Дүүргийн нэр	Гүйцэтгэгч сонгон шалгарсан		Үүнээс түүвэрт хамруулсан		Үүнээс илэрсэн зөрчил	
		Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ
1	БЗД	75	67,945.2	45	56,506.0	11	20,306.5
2	ХУД	116	100,960.6	56	94,201.6	4	7,207.1
3	СБД	158	78,265.2	60	62,861.3	6	5,763.4
4	СХД	66	26,504.5	30	24,096.1	5	2,245.0
5	НД	26	2,021.4	5	1,692.9	2	1,155.1
6	БГД	69	37,434.6	36	28,164.2	4	733.7
7	ЧД	54	12,728.2	28	9,894.6	2	85.7
8	БНД	38	6,751.7	26	6,210.9	-	-
9	БХД	13	962.9	6	909.8	-	-
НИЙТ		615	333,574.4	292	284,537.5	34	37,496.5

ТББ-т заасан ерөнхий шаардлагыг хангаагүй, санхүүгийн чадавх, ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага, ажил гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчний шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Тухайлбал:

БГД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Сод дэлхий групп” ХХК-ийн шалгарсан 144.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилт бүтээн байгуулалтын ажил. ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгө нь 150.0 сая төгрөгөөс багагүй байх шаардлагад “Хаан банкны 2024.09.18-ны өдрийн 5219/01/317 тоот албан бичгээр банк бодитой санхүүгийн үүрэг хүлээгээгүй, судлагдаагүй зээлийн тодорхойлолт ирүүлсэн”;
- “Стөунхиж” ХХК-ийн шалгарсан 293.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилт, бүтээн байгуулалтын ажил. ТББ-т тусгагдсан 150.0 сая төгрөгөөс багагүй дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх шаардлагыг хангаагүй;
- “Хан дуулга” ХХК-ийн шалгарсан 151.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилт үйлчилгээний тусгай зориулалтын техник худалдан авах ажил. Хуулийн 7.1-д заасан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдэл, ТББ-ийн V бүлгийн Маягт 3 /үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл/, Маягт 5 /хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл/-ын дагуу бэлтгэсэн мэдээллийг тус тус баталгаажуулж ирүүлээгүй, ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх шалгуурыг хангаагүй;

- “Мон жап стар” ХХК-ийн шалгарсан 145.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй онцгой байдлын хэлтэст автомашин худалдан авах ажил. ТББ-т үйлдвэрлэгчтэй хийсэн гэрээ, каталогуудыг орчуулаагүй, монгол хэл дээр ирүүлээгүй;

БЗД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Дабль Пирамид констракшн” ХХК-ийн шалгарсан 2,196.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилтын ажил. ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгө нь 2,196.4 сая төгрөгөөс багагүй байх шаардлагад банк бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн зээлийн тодорхойлолт ирүүлээгүй;
- “Гэрэлтүүлэг чимэглэл” ХХК-ийн шалгарсан 2,674.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 21 дүгээр хорооны гэрэлтүүлгийн ажил. ТББ-т 2,674.9 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй гэрэлтүүлгийн ажил гүйцэтгэсэн байх шаардлагыг хангаагүй /гүйцэтгэгч 2,463.6 сая төгрөгийн үнийн дүнтэй ажил санал ирүүлсэн/;
- “Калдеротубо” ХХК-ийн шалгарсан 940.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 6, 15, 42, 43 дугаар хороодын дээвэр засварын ажил. Ижил төстэй ажилд санал болгосон ажлын дүн 940.9 сая төгрөгөөс багагүй байх шалгуурыг хангаагүй;
- “Оргил дельта трейд” ХХК-ийн шалгарсан 286.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй замын цагдаагийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажил. ТББ-т нийлүүлэх барааны каталог, хэрэгжүүлж байгаа гэрээний мэдээллийг монгол хэл дээр ирүүлээгүй, санал болгож буй барааг каталоогоос ялган тодруулаагүй, түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ 300.0 сая төгрөгөөс дээш байх шаардлагад банк бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн зээлийн тодорхойлолт ирүүлээгүй;
- “Цагаан бургалтай” ХХК-ийн шалгарсан 4,805.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 11 дүгээр хорооны 64 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажил. ТББ-т заасан 3,364.0 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй барилга угсралтын ажил гүйцэтгэсэн байх шалгуурыг хангаагүй;
- “Би жи роял” ХХК-ийн шалгарсан 204.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 10 дугаар хорооны автобусны буудлын тохижилтын ажил. ТББ-т заасан 2022, 2023 он тус бүр 204.0 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх шалгуурыг хангаагүй;
- “Зост цагаан” ХХК-ийн шалгарсан 215.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 2 дугаар хорооны тохижилтын ажил. ТББ-т заасан 2022, 2023 он тус бүр 215.4 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх шалгуурыг хангаагүй;
- “Сант баян бэрх” ХХК-ийн шалгарсан 1,867.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 37 дугаар хорооны 0.668 км авто замын ажил. Ажил гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчин нь авто замын инженер байх болон “Эрчим хүчний яамнаас олгодог 03.2.1, БА-3.5 тусгай зөвшөөрөлтэй байх” шалгуурыг хангаагүй, ажилтнуудын НДШ төлөлтийн сүүлийн 1 жилийн тодорхойлолтыг НД-8 маягтын дагуу ирүүлээгүй;
- “Булган өндөр” ХХК-ийн шалгарсан 4,246.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 20, 33 дугаар хорооны 3 км авто замын ажил. ТББ-т заасан ажил гүйцэтгэх хүний нөөцийн болон техникийн чадавхын шаардлагыг хангаагүй;
- “Цагаанаа амка” ХХК-ийн шалгарсан 1,840.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй Баянзүрх Эко тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ, Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн ААТҮГ-т болон бусад хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажил. ТББ-т заасан гүйцэтгэлийг хариуцах ажилтны мэдээллийг ирүүлээгүй, ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын шалгуурыг хангаагүй;
- “Ган мөнхжин” ХХК-ийн шалгарсан 1,028.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 дүгээр хорооны гадна фасад засварын ажил. ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ нь 1,028.7 сая төгрөгөөс дээш байх шалгуурт банк бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн тодорхойлолт ирүүлээгүй, фасадын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх шалгуурыг хангаагүй.

НД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ-нд:

- “Велдедлайне Монголиа” ХХК-ийн шалгарсан 1,088.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй Илч хотхоноос Наадмын хэсгийн шинэ зам хүртэлх авто замын ажил. ТББ-т заасан түргэн

хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ нь 1,090.0 сая төгрөгөөс дээш байх шалгуурт банк бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн тодорхойлолт ирүүлээгүй, ажил гүйцэтгэх ИТА болон НДШ төлөлтийн лавлагааг ирүүлэх шаардлагыг хангаагүй;

- “Велдедлайне Монголиа” ХХК-ийн шалгарсан 67.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй авто замын нүхэн эвдрэлийг хэсэгчлэн засварлах ажил. ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ нь 33.5 сая төгрөгөөс багагүй байх шаардлагад банк бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн тодорхойлолт ирүүлээгүй, санал болгосон ижил төстэй ажлын хүлээн авсан комиссын дүгнэлт, захиалагчийн тодорхойлолт, V бүлгийн Маягт 2, 3-ын дагуу бэлтгэсэн мэдээллийг тус тус ирүүлээгүй.

СБД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ-нд:

- “Арвинсантех” ХХК-ийн шалгарсан 107.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 68-р цэцэрлэгийн хашаа шинэчлэх ажил. ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгө нь 108.2 сая төгрөгөөс багагүй байх шаардлагад банк бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн тодорхойлолт ирүүлээгүй, ажил гүйцэтгэх хүний нөөцийн болон НДШ төлөлтийн талаарх тодорхойлолт ирүүлэх шаардлагыг хангаагүй;
- “Зууны ирээдүй” ХХК-ийн шалгарсан 145.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 75-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, эд хогшил, машин тоног төхөөрөмж. ТББ-т заасан барааг хүлээлгэн өгөх хүргэлтийн 2 автомашины гэрчилгээг ирүүлээгүй, түрээсийн гэрээнд тухайн ажлын нэр, дугаарыг тусгаагүй, санал болгож буй барааны гарал үүслийн гэрчилгээ, үйлдвэрлэгчийн итгэмжлэл, зөвшөөрөл зэргийг ирүүлээгүй;
- “Ньюсиндкат” ХХК-ийн шалгарсан 395.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй цагдаагийн хэлтсийн хяналтын байр барих ажил. ТББ-т заасан Маягт 5-ын дагуу хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл ирүүлээгүй;
- “Цэцэглэлтийн үе” ХХК-ийн шалгарсан 564.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1, 2-р хорооны авто зогсоол, тохижилтын ажил. Тендер нээсэн өдрийн байдлаар гүйцэтгэгч татварын болон НДШ-ийн өр төлбөртэй байгаа нь ерөнхий шаардлагыг хангаагүй, ТББ-т заасан тээврийн хэрэгслийн албан татвар, зам ашигласны төлбөр төлсөн баримтыг ирүүлээгүй, ерөнхий инженерийн тухайн байгууллагад ажилласныг нотлох НДШ төлөлтийн тодорхойлолтыг ирүүлээгүй, НД №7, НД№8 маягтаар гаргасан тайлангийн хуулбарыг ирүүлээгүй, зураг төсөв боловсруулах ажлын хүрээнд мэргэжлийн болон бусад ажилтны мэдээллийг ирүүлээгүй;
- “Үүлэн сүндэр” ХХК-ийн шалгарсан 590.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 7-р хороо, 2-р сургуулийн гадна фасад засварын ажил. ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгө нь 594.5 сая төгрөгөөс багагүй байх шаардлагад банкны бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн тодорхойлолт ирүүлээгүй;
- “Сүвэн уул” ХХК-ийн шалгарсан 3,961.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-т машин механизм нийлүүлэх ажил. ТББ-т заасан зээлийн мэдээллийн сангийн лавлагаа нь ерөнхий шаардлагыг хангаагүй, тендерт санал болгож буй автомашин үйлдвэрлэгчийн албан ёсны төлөөлөгч байх, засвар үйлчилгээний туршлагатай, ажил гүйцэтгэх хүний нөөцийн чадавхын шаардлагуудыг хангаагүй.

СХД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ-нд:

- “Люкс даймонд” ХХК-ийн шалгарсан 654.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 264 дүгээр цэцэрлэгийн гадна талбайн тохижилтын ажил. ТББ-т заасан хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээний мэдээлэл, байгаль орчин, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай ногоон орчныг бүрдүүлэх мэдэгдлийг тус тус ирүүлээгүй;
- “Эс Жи Би Глобал” ХХК-ийн шалгарсан 499.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй автобусны буудал шинээр байгуулах ажил (5 байршилд). ТББ-т заасан ажил гүйцэтгэх хүний нөөцийн шалгуурыг хангаагүй, тендерт шалгарсан тохиолдолд захиалагчийн баталсан гэрээний үнэ, хугацаа, зураг, төсвийн дагуу ажлыг дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг ирүүлээгүй;

- “Хорол хүнс” ХХК-ийн шалгарсан 191.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй Дэд бүтцийн хөгжлийн албанд тоног төхөөрөмж нийлүүлэх ажил. ТББ-т үйлдвэрлэгчтэй хийсэн гэрээ, каталогуудыг орчуулаагүй, монгол хэл дээр ирүүлээгүй;
- “Харанданхайрхан” ХХК-ийн шалгарсан 290.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй Биеийн тамир спортын хороонд тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх ажил. ТББ-т үйлдвэрлэгчтэй хийсэн гэрээ, каталогуудыг орчуулаагүй, монгол хэл дээр ирүүлээгүй;
- “Монгол туургатны зам” ХХК-ийн шалгарсан 608.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 9,10,37-р байр орчмын тохижилтын ажил. ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн шаардлагад арилжааны банкны бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн зээлийн тодорхойлолт ирүүлээгүй.

ХУД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ-нд:

- “Эко эрин тохижилт” ХХК-ийн шалгарсан 368.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй зам цэвэрлэгээ арчилгаанд шаардлагатай авто машин механизм, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил. ТББ-т заасан ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл, барааны үнийн задаргаа, нийлүүлэлтийн хуваарь, гэрээний гүйцэтгэлийг хариуцах ажилтны мэдээлэл, үйлдвэрлэгчтэй хийсэн гэрээ, каталогуудыг орчуулаагүй, монгол хэл дээр ирүүлээгүй, үйл ажиллагаа эрхлэх чиглэлд тавигдах шаардлагыг хангаагүй;
- “Иг” ХХК-ийн шалгарсан 1,383.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй Баруун Сонсголонгийн гудамжнаас Буянт-Ухаа 23 дугаар гудамж дагуу центр хүртэлх авто замын ажил. ТББ-т заасан ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын шаардлагыг хангаагүй;
- “Жаклин” ХХК-ийн шалгарсан 3,999.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 20 дугаар хорооны цэцэрлэгийн барилга. ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгө нь 1,200.0 сая төгрөгөөс багагүй байх шаардлагад банкны бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн тодорхойлолт ирүүлээгүй;
- “Норовтүн” ХХК-ийн шалгарсан 1,456.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 19, 20 дугаар хорооны хороолол дундах зам засвар, шинэчлэлтийн ажил. ТББ-т заасан ажил гүйцэтгэх хүний нөөцийн болон техникийн чадавхын шаардлагыг хангаагүй.

ЧД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ-нд:

- “Эко мийт” ХХК-ийн шалгарсан 36.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй цэргийн штабт шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажил. ТББ-т заасан санал болгож буй барааны каталогийг ирүүлээгүй;
- “Стандарт Резиденс Констракшн” ХХК-ийн шалгарсан 48.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй Баянбүрдийн тойргийн замын цагдаагийн постын засварын ажил. Гүйцэтгэгч нь тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр төлбөртэй байгаа нь ерөнхий шаардлага хангаагүй, ТББ-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгө нь 50.0 сая төгрөгөөс багагүй байх шаардлагад банк бодитой санхүүгийн үүрэг хүлээсэн зээлийн тодорхойлолт болон ерөнхий инженерийн ажилласан жилийг нотлох НДШ төлсөн лавлагааг ирүүлээгүй.

Эдгээр нь ТБОНӨХБАУХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасан “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Цаашид илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг үнэн зөвөөр үнэлэх, шаардлага хангасан гүйцэтгэгч сонгон шалгаруулаагүй зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт: Гүйцэтгэгч сонгон шалгаруулсан төсөл арга хэмжээнээс 37,496.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 34 худалдан авах ажиллагаа тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй байна.

Б.2. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь холбогдох зураг төсөв, техникийн шаардлагын дагуу хяналт хэрэгжүүлж, хүлээн авсан уу?

Дүүргүүдэд өмнөх оноос дамжин хэрэгжсэн болон шинээр эхэлсэн 522,256.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 822 ТАХ-ний гүйцэтгэлд дүүргүүдийн ЗДТГ, НЗХГ, “НХОГ”, СХД-ийн Захиалагчийн алба, “Хан-Уул яармаг” ОНӨААТҮГ, “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨТҮГ, Баянзүрх дүүргийн хөгжлийн төв зэрэг байгууллагууд захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

Дүүргүүдийн хэмжээнд 522,256.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 822 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2024 онд 223,260.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 578 ТАХ хэрэгжиж дууссан байна.

Хүснэгт 9. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт

(сая.төг)

№	Дүүргийн нэр	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	Хэрэгжиж дууссан ажил		Он дамжин хэрэгжиж байгаа		Хэрэгжээгүй	
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	БГД	87	44,883.1	63	23,307.9	17	15,442.9	7	6,132.3
2	БЗД	129	135,913.7	75	54,282.9	38	67,063.0	16	14,567.8
3	БНД	55	7,596.4	39	3,168.0	6	3,166.6	10	1,261.8
4	БХД	13	962.9	10	567.7	-	-	3	395.3
5	НД	28	1,970.8	27	882.5	1	1,088.0	-	-
6	СБД	172	112,817.1	134	49,172.5	29	54,511.6	9	9,133.0
7	СХД	78	32,736.6	60	18,738.4	16	13,595.2	2	403.0
8	ХУД	183	149,025.9	116	65,128.0	36	72,539.0	31	11,358.9
9	ЧД	77	36,350.4	54	8,012.6	11	27,791.9	12	545.9
НИЙТ				578	223,260.5	154	255,198.0	90	43,798.2

Харин 255,198.0 сая төгрөгийн дүнтэй 154 ТАХ нь 10-95 хувийн гүйцэтгэлтэй буюу он дамжин хэрэгжиж байгаа, 43,798.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 90 ТАХ тайлант онд хэрэгжээгүй байна. Эдгээр нь дараах шалтгаантай байна.

- БЗД-т хийгдсэн 1,663.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 0.9 км авто зам, зогсоолын ажлын гүйцэтгэгч “Сэтгэшгүй нэмэх” ХХК. Тус ажлын авто замын ажил хийгдэж дууссан, зураг төсөв удааширнаас шалтгаалж гэрэлтүүлэг явган замын ажил дулааны улиралд дуусаагүй;
- БГД-ийн Ерөнхий боловсролын 78, 96, Сэтгэмж цогцолбор сургууль, 88 дугаар цэцэрлэгүүдэд хийгдсэн 135.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй боловсролын байгууллагуудад хашаа суурилуулах ажлын гүйцэтгэгч “Нанодизель Трейд” ХХК. Тус ажил дулааны улиралд хийх шаардлага үүсч технологийн зогсолт хийсэн;
- ХУД-т хийгдсэн 250.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй явган зам, замын байгууламжийн ажлын гүйцэтгэгч “Билигт-Инжинеринг” ХХК. Тус ажил цаг агаарын хоногийн дундаж температур 0 градусаас бага болж өвлийн нөхцөлд шилжсэнтэй холбогдуулан зогсоосон.

Тайлант онд хэрэгжиж дууссан 223,260.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 578 ТАХ-ний төрөл бүрээс 162,045.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 291 ТАХ-г аудитын түүвэрт хамруулан шалгахад зураг төсөвт тусгагдсан ажлуудыг бүрэн хийгээгүй, чанартай гүйцэтгээгүй, техникийн тодорхойлолтод заасан барааг нийлүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Хүснэгт 10. Түүвэрт хамрагдсан ТАХ-нд илэрсэн зөрчил


(сая.төг)

№	Дүүргийн нэр	Хэрэгжиж дууссан		Үүнээс түүвэрт хамруулсан		Үүнээс илэрсэн зөрчил	
		Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ
1	БГД	63	23,307.9	30	11,581.0	6	6,548.4
2	БЗД	75	54,282.9	44	46,077.3	9	11,804.2
3	БНД	39	3,168.0	20	2,165.9	-	-
4	БХД	10	567.7	3	514.6	-	-
5	НД	27	882.5	10	557.2	-	-
6	СБД	134	49,172.5	50	33,977.3	-	-
7	СХД	60	18,738.4	30	24,096.1	11	3,453.8
8	ЧД	54	8,012.6	38	9,733.6	4	1,047.4
9	ХУД	116	65,128.0	66	49,318.6	3	2,355.3
НИЙТ		578	223,260.5	291	162,045.4	33	25,209.1

Энэ нь МУЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.6-д “Захиалагч зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Баянгол дүүрэг:

- БГД-ийн 24 дүгээр хороонд хийгдсэн 4,849.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй цэцэрлэгийн барилга худалдан авах ажлын гүйцэтгэгч “Эгэл трейд” ХХК. Цэцэрлэгийн барилгын 1,2,3 дугаар давхруудын өрөө болон коридорын хана цууралт өгч хагарсан, нойлын өрөөний тааз ус алдаж эвдэрсэн.



- БГД-ийн Эрүүл мэндийн төвд нийлүүлсэн 175.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй түргэн тусламжийн тусгай зориулалттай тээврийн хэрэгсэл худалдан авах ажлын гүйцэтгэгч “Монгол Хьюндай Автомотив” ХХК. Автомашин нийлүүлэхдээ тусгай зориулалтын тоноглол хэрэгслийг суурилуулаагүй.



- БГД-ийн ерөнхий боловсролын сургуульд тоног төхөөрөмж нийлүүлэх 88.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй ажлын гүйцэтгэгч “Ай Ти Зон” ХХК. Тухайн хороонд төлөвлөгдсөн сургууль ашиглалтад ороогүй учир нийлүүлсэн тоног төхөөрөмжийг агуулахад хадгалж ашиглалтгүй байна.



- БГД-ийн 23 дугаар хороонд хийгдсэн 145.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилт бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгч “Анбо”ХХК. Тус ажлын сагсан бөмбөгийн талбайн тэмдэглэгээ арилсан, сандлын түшлэг хугарсан, сагсны шийдийн зөөлөвч урагдсан.



- БГД-ийн 5,6,7,8 дугаар хороонд хийгдсэн 649.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилт бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгч “Тэгш хүслийн гэрэл” ХХК. Хүүхдийн чийрэгжүүлэх тоглоом эвдэрсэн, сагсны 2 шийдийн цагираг эвдэрсэн, хашаа татсан олс тасарсан, сагсны талбайн хашааны гагнаас салсан, гулсуурын тоглоомын боолт суларсан.



- БГД-ийн 9, 12, 14, 15 дугаар хороонд хийгдсэн 640.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилт бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгч “Люксдаимонд” ХХК. Тус ажилд хийгдсэн хүүхдийн эргэдэг тоглоом эвдэрсэн, хашааны олс тасарсан, чийрэгжүүлэх төхөөрөмж эвдэрсэн.



Баянзүрх дүүрэг:

- БЗД-ийн 25 дугаар хороонд хийгдсэн 2,960.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 2 км авто замын ажлын гүйцэтгэгч “Хайрхан уулын зам” ХХК. Замын тэмдэглэгээ, замын хажуугийн хөвөө, хурд сааруулагч, мэдээлэх самбар, далангийн амсрын бэхэлгээ, зүлэгжүүлэлт, шуудуу цэвэрлэгээ зэрэг ажил хийгдээгүй;



- БЗД-ийн 34 дүгээр хороонд хийгдсэн 3,320.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 2.3 км авто замын ажлын гүйцэтгэгч "Тотал-Инж" ХХК. Явган хүний замын хөтөч хавтангийн тэмдэглэгээ хийгээгүй, зорчих хэсэгт замын хагарал үүссэн;



- БЗД-ийн улсын бүртгэлийн хэлтэст 745.1 сая төгрөгийн дүнтэй тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгч "Ньюкомпас" ХХК. Жолооны үнэмлэх хэвлэх болон 29 киоск машины зөвшөөрөл ЦЕГ-аас ирээгүй, мэргэжлийн инженергүй зэргээс шалтгаалан ашиглалтгүй байна.



- БЗД-ийн 2 дугаар хороонд хийгдсэн 1,634.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1.08 км авто замын ажлын гүйцэтгэгч "Таны зам" ХХК. Зүлэг, ногоон байгууламжийг дахин сэргээгээгүй, замын заадсыг нөхөөгүй, явган хүний замын хөтөч хавтангийн тэмдэглэгээ хийгээгүй, эргэлтийн хашлага эвдэрснийг засварлаагүй;



- БЗД-ийн 24 дүгээр хороонд хийгдсэн 750.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 0.51 км авто замын ажлын гүйцэтгэгч "Шинэ цагийн зам" ХХК. Замын бродюрыг зураг төсөвт заасны дагуу гүйцэтгээгүй (*бродюр хооронд 15-20 см зайтай*).



- БЗД-ийн 13 дугаар хороонд хийгдсэн 1,089.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 0.55 км авто замын ажил гүйцэтгэгч “Хайрхан уулын зам” ХХК. Авто замын бродюр эвдрэл ихтэй, дулааны шугамын узель замын траст орсон, замын ажлууд бүрэн хийгдээгүй.



- БЗД-т хийгдсэн 327.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй прокурорын газрын засварын ажлын гүйцэтгэгч "Гурвангис" ХХК. Засварын ажлын паркетан шал зай гарсан, эвдрэл ихтэй, чанарын шаардлагыг бүрэн хангаагүй;



- БЗД-ийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг саадгүй хүргэх зорилгоор хэрэгжүүлсэн 728.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй хороодын байрны засварын ажлын гүйцэтгэгч "Улаан-Элс" ХХК. Ажлын тоо хэмжээнд заагдсан налуу замын резин болон засварын ажлыг чанартай хийгээгүй;



- БЗД-ийн 41 дүгээр хороонд хийгдсэн 248.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилтын ажлын гүйцэтгэгч "Шинэ эрин инженеринг" ХХК. Зураг төсөвт тусгагдсан явган замын тэмдэглэгээ хийгээгүй.



Сонгинохайрхан дүүрэг:

- СХД-ийн 27 дугаар байрны хойд талд хийгдсэн 365.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй гадна талбайн тохижилт, авто зам, зогсоолын ажлын гүйцэтгэгч “Эн би Девелопмент” ХХК. Хүүхдийн тоглоомын савлуур, явган хүний замын хавтан, 2 хогийн сав эвдэрсэн.



- СХД-ийн тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний албанд нийлүүлсэн 800.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй хог тээврийн авто машин худалдан авах ажлын гүйцэтгэгч “Хантуул трейд” ХХК. Камаз маркийн авто машин цахилгааны гэмтэлтэй учир бүрэн хүчин чадлаар ашиглах боломжгүй байна.



- СХД-ийн 9,10,37 дугаар байрны орчим хийгдсэн 608.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилтын ажлын гүйцэтгэгч “Монгол туургатны зам” ХХК. Авто замын асфальт цуурсан, ажлын тоо хэмжээнд заагдсан гантиг чулуу наах болон ногоон байгууламжийн ажил хийгдээгүй.



- Авто зам, замын байгууламж бүхий гадна талбайн 324.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй тохижилтын ажлын гүйцэтгэгч “Монгол туургатны зам” ХХК. Явган хүний замын хавтангийн хашлага бетон 2 байршилд эвдэрсэн, авто замын бродюрын уналт хэсгийг хийгээгүй, тоглоомын талбайн савлуур алга болсон.



- Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хийгдсэн 76.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй барилгын 1 дүгээр давхрын үүдний хэсэг, хонгилын интерьерийн угсралтын ажлын гүйцэтгэгч “Дөлгөөн хангайн түшиг” ХХК. Барилгын хананд хагарал үүссэн.



- СХД-ийн Хангайн 80 дугаар гудамжнаас 34 дүгээр байрны гүүр хүртэл хийгдсэн 210.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй замын байгууламж бүхий гудамж талбайн тохижилтын ажлын гүйцэтгэгч “Хэрмээдэй” ХХК. Явган хүний замын бродюр 2 ширхэг эвдэрсэн.



- СХД-ийн 6 дугаар хороонд хийгдсэн 141.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй явган хүний зам шинээр хийх ажлын гүйцэтгэгч “Дайт шагай” ХХК. Явган хүний зам зарим хэсэгт хагарч эвдэрсэн.



- СХД-ийн 28 дугаар хороонд хийгдсэн 84.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй сагсан бөмбөгийн талбайн засварын ажлын гүйцэтгэгч “Дайт шагай” ХХК. Хашааны хаалга болон торны гагнаас салсан.



- СХД-ийн 151 дүгээр сургуулийн урд талд хийгдсэн 170.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй авто зогсоолын нэмэлт ажлын гүйцэтгэгч “Булган Өндөр” ХХК. Явган хүний замын асфальтад хагарал үүссэн.



- СХД-ийн 10 байршилд хийгдсэн 479.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй автобусны буудал шинээр байгуулах нэмэлт ажлын гүйцэтгэгч “Эс Би Жи Глобал” ХХК. Дотор хана, тааз эвдэрсэн.



- СХД-ийн Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ-т 194.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Хорол хүнс” ХХК. Явган хүний замын хавтан үйлдвэрлэх тоног төхөөрөмж худалдан авсан хэдий ч ажлын байрны асуудлыг шийдвэрлээгүйгээс ашиглалтгүй байна.



Хан-уул дүүрэг:

- Дүүргийн спорт хорооны барилгын 821.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй спорт заал, дотор их засварын ажлын гүйцэтгэгч “Сонгинотамир” ХХК. 1 дүгээр давхрын коридорын хана цуурсан.



- ХУД-ийн эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай 573.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй компьютер худалдан авах ажлын гүйцэтгэгч “Би Си Ти” ХХК. зөөврийн компьютер 161 ширхгийг худалдан авсан боловч ашиглалтгүй байна.
- ХУД-ийн боловсролын байгууллагуудад нийлүүлэх 960.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгч “Бодь-Электроникс” ХХК. Зөөврийн 1000 ширхэг компьютер нийлүүлснээс 159 ширхгийг шинээр байгуулагдах хороодод өгөхөөр агуулахад хадгалж байна.



Чингэлтэй дүүрэг:

- ЧД-ийн 149 дүгээр сургуулийн урд хийгдсэн 595.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй авто зогсоол, автобусны буудал, авто замын ажлын гүйцэтгэгч “Нано-Экологи” ХХК. Авто замын бродюр бутарсан, явган хүний замын хөтөч хавтан хагарч эвдэрсэн.
- ЧД-ийн 19 дүгээр хороонд хийгдсэн 131.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй автобусны буудлын тохижилтын ажлын гүйцэтгэгч “Нано-Экологи” ХХК. Явган хүний замын чигжээс бүрэн хийгээгүй, замын хавтан зарим хэсэгт цөмрөлттэй, замын бродюр эвдрэлтэй, заадсыг бетонодоогүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч хавтан эвдрэл ихтэй байна.



- Дүүргийн хурдан цэгийн үйл ажиллагааг тогтмолжуулахад шаардлагатай 34.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгч Ай Ти Зон ХХК. Киоск 14 төхөөрөмжид программ уншуулаагүй шалтгаанаар 2024 оны 9 дүгээр сараас хойш ашиглаагүй.



- ЧД-ийн ЗДТГ-ын албан хаагчдад шаардлагатай 285.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй тоног төхөөрөмж авах ажлын гүйцэтгэгч “Нанодизель трейд” ХХК. Тус компани нь техникийн тодорхойлолтод нийцсэн лайв төхөөрөмжийг нийлүүлээгүй, зах зээлийн үнээс зөрүүтэй байна.



Иймд гүйцэтгэгчийн болон захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй албан хаагчдын үүрэг хариуцлагыг сайжруулах, эвдэрсэн болон чанаргүй гүйцэтгэсэн ажлуудыг дахин хийлгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дүгнэлт: Аудитын түүвэрт хамрагдсан төсөл арга хэмжээний 11.3 хувь буюу 33 төсөл арга хэмжээнд зураг төсөвт тусгагдсан ажлуудыг бүрэн хийгээгүй, чанартай гүйцэтгээгүй зөрчлүүд илэрч байна.

БҮЛЭГ В. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ШИЙДВЭРЛЭЖ, ХӨРӨНГӨ БҮРТГЭЛД ТУСГАСАН ЭСЭХ

В.1. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих арга хэмжээг бүрэн тусгасан уу?

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, ... дуусгах”-аар заасан.

Дүүргүүдийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих 33 ТАХ-ний санхүүжих дүнг 21.6-3,200.0 сая төгрөг буюу 1.7-47.7 хувиар дутуу тусгасан байна. **Хавсралт 6.**

Иймд ТАХ-г хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан дүнгээс багагүй байхаар тооцож, зөрчлийг давтан гаргахгүй байх шаардлагатай байна.

Дүгнэлт: Дүүргүүдийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих 33 ТАХ-ний санхүүжих дүнг бүрэн тусгаагүй байна.

В.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон уу?

Дүүргүүдийн төсвийн хөрөнгөөр шинэ болон шилжих 839 ТАХ-нд 2024 онд 463,170.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 662 ТАХ 305,871.1 сая төгрөг буюу 66.0 хувийн санхүүжилт олгосон.

Үүнээс өмнөх оноос дамжин санхүүжих 227 ТАХ-нд 114,794.7 сая төгрөгийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 76,881.9 сая төгрөг буюу 67.0 хувийн санхүүжилт олгож, шинээр хэрэгжих 612 ТАХ-нд 348,375.7 сая төгрөгийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 228,989.2 сая төгрөг буюу 65.7 хувийн санхүүжилт олгожээ.

Хүснэгт 11. ТАХ-ний санхүүжилтийн судалгаа

(сая.төг)

№	Дүүргийн дүн	Өмнөх оноос хэрэгжсэн				2024 онд шинээр хэрэгжсэн				Нийт			
		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХУД	56	22,391.1	53	18,133.8	112	76,919.6	99	57,606.8	168	99,310.7	152	75,740.6
2	СБД	24	24,143.9	17	15,324.0	117	115,637.0	86	57,020.7	141	139,780.9	103	72,344.7
3	БЗД	52	33,672.5	46	20,307.4	69	55,175.1	61	50,095.0	121	88,847.7	107	70,402.4
4	БГД	18	6,727.7	16	5,199.2	78	36,828.2	64	23,918.2	96	43,555.9	80	29,117.4
5	СХД	19	6,764.3	10	3,768.5	77	33,934.6	63	22,547.1	96	40,699.0	73	26,315.6
6	ЧД	28	18,635.0	21	12,329.7	73	20,596.6	43	13,013.0	101	39,231.7	64	25,342.7
7	БНД	26	2,320.0	22	1,691.5	45	5,949.6	23	2,519.1	71	8,269.6	45	4,210.6
8	НД	3	127.8	3	127.8	27	2,335.5	25	1,701.6	30	2,463.3	28	1,829.4
9	БХД	1	12.4	-	-	14	999.4	10	567.7	15	1,011.6	10	567.7
НИЙТ		227	114,794.7	188	76,881.9	612	348,375.7	474	228,989.2	839	463,170.4	662	305,871.1

Нийт санхүүжсэн 305,871.1 сая төгрөгийн 1.2 хувь буюу 3,732.2 сая төгрөгийг техник хяналт, магадалшгүй ажил, зохиогчийн хяналтын зардал эзэлж байна.

Хэрэгжиж дууссан ТАХ-ний 11,610.2 сая төгрөгийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж, гэрээний үүргээ зөрчсөн 57 гүйцэтгэгчээс хугацаа хэтрүүлсэн алдангид 162.3 сая төгрөгийг суутган тооцож, дүүргийн төрийн сангийн дансанд байршуулжээ.

Хүснэгт 12. 2024 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт, барьцаа, алданги

(сая.төг)

№	Дүүргийн нэр	Батлагдсан санхүүжих дүн		Олгогдсон санхүүжилт		Барьцаанд		Алданги	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХУД	168	99,310.7	152	75,740.6	93	3131.3	26	94.0
2	СБД	141	139,780.9	103	72,344.7	94	3,292.1	-	-
3	БЗД	121	88,847.6	107	70,402.4	75	2,767.5	8	15.2

4	БГД	96	43,555.9	80	29,117.4	59	1,071.5	7	14.5
5	СХД	96	40,699.0	73	26,315.6	57	777.9	5	8.4
6	ЧД	101	39,231.7	64	25,342.7	32	345.7	6	29.5
7	БНД	71	8,269.6	45	4,210.6	32	153.4	3	0.5
8	НД	30	2,463.3	28	1,829.4	25	42.4	-	-
9	БХД	15	1,011.7	10	567.7	10	28.4	2	0.2
НИИТ		839	463,170.4	662	305,871.1	477	11,610.2	57	162.3

Санхүүжилт олгосон дансны хуулга, гэрээний хэрэгжилттэй холбоотой баримтуудыг /гэрээ дүгнэсэн протокол, ажлын гүйцэтгэл, ажил хүлээлцсэн актууд/ шалгахад гэрээний хугацаа хэтрүүлсэн, алданги тооцоогүй зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Хүснэгт 13. Гэрээний алданги дутуу тооцсон ТАХ

(сая.төг)

№	Дүүргийн нэр	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний дүн	Алдангийн хувь	Алданги тооцоогүй хоног	Алдангийн дүн
1	ХУД	Ерөнхий боловсролын сургуулиудад шаардлагатай үндсэн болон туслах тоног төхөөрөмж худалдан авах гэрээ	"Чиглэл" ХХК	446.9	0.5	4	8.9
2	ЧД	Шинэ хороодод тавилга тоног төхөөрөмж нийлүүлэх	"Монтех дистрибьюшн" ХХК	197.8	0.5	5	4.9
3	ХУД	Үерийн эрсдэлээс хамгаалах зөөврийн тоног төхөөрөмж худалдан авах гэрээ	Престиж инженеринг" ХХК	197.9	0.5	1	0.5
4	ХУД	Эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай компьютер худалдан авах гэрээ	"Би Си Ти" ХХК	573.0	0.05	1	0.3
5	СХД	Байрны фасад засварын ажил Багц3	"Уулс дөл" ХХК	252.4	0.5	2	0.1
НИИТ				1,668.0			14.7

Дээрх ажлуудын гэрээний хугацааг 1-5 хоногоор дутуу тооцсон, нийт 14.7 сая төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан банкин дахь НТАГ-ын хүү торгуулийн орлогын 100200000908 дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Мөн ЗГ-ын 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.13⁴ заасныг зөрчин урьдчилгаа төлбөрийг нийт санхүүжилтийн 30 хувиас хэтрүүлэн олгосон байна. Тухайлбал:

Хүснэгт 14. Урьдчилгаа төлбөрт илүү олгосон санхүүжилт

(сая.төг)

№	Дүүргийн нэр	Байгууллагын нэр	Гэрээний дугаар	Гэрээний үнэ	2024 онд санхүүжих дүн	Урьдчилгаа төлбөрийн баталгаа		Илүү олгосон санхүүжилт хувь
						олгосон	Огноо	
1	ХУД	Вишнделопмент ХХК	ХО/146	13,249.4	3,600.0	3,600.0	2024.10.16	100.0
2	ХУД	Жаклин ХХК	ХО/91	3,999.1	1,300.0	950.0	2024.08.23	73.1
3	СБД	"Тотал-Идеал" ХХК		3397.7	3397.7	2000.0	2024.09.25	58.8
4	ХУД	Голден дрийм ХХК	ХО/129	689.2	689.2	230.0	2024.09.18	33.3
				21,335.4	8,986.9	6,780.0		

Дээрх компаниудад урьдчилгаа төлбөрийн санхүүжилт олгохдоо нийт санхүүжилтийн 30 хувиас хэтрүүлэн 3.3-70.0 хувиар илүү олгосон байна.

ЧД-ийн ЗДТГ нь 285.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй "ЧД ЗДТГ-ын Албан хаагчдад шаардлагатай тоног төхөөрөмж авах ажил"-д "Нанодизель трейд" ХХК-тай гэрээ байгуулсан байна. Тус компанийн нийлүүлсэн лайв төхөөрөмж нь техникийн тодорхойлолтод зааснаас өөр загвартай, зах зээлийн үнийн дүнгээс өндрөөр нийлүүлсэн

⁴ Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна;

учир үнийн дүнгийн зөрүү 7.1 сая төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан банкин дахь НТАГ-ын хүү орлогын 100200000908 дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Цаашид ТАХ-ний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгох, гэрээний алдангийн хоногийг бүрэн тооцох, урьдчилгаа төлбөрийг холбогдох журамд нийцүүлэн олгох зэрэг зөрчлүүдийг давтан гаргахгүй ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт: Дүүргүүд нь тайлант болон өмнөх онуудаас хэрэгжсэн нийт 662 ТАХ-нд батлагдсан санхүүжилтийн 65.1 хувийг олгосон байна.

В.3. Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг өмчийн бүртгэлд тусгасан уу?

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 578 ТАХ бүрэн хэрэгжиж дууссанаас барилга байгууламж, авто зам, дэд бүтцийн чиглэлийн 127 ТАХ, техник, тоног төхөөрөмжийн 177 ТАХ, их засвар, тохижилтын ажлын 210 ТАХ, зураг төсөв, бусад 64 ТАХ байна.

Бүрэн хэрэгжсэн ТАХ-ээс 153,329.4 сая төгрөгийн дүнтэй 382 ТАХ-г ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгасан, 12,082.6 сая төгрөгийн дүнтэй 7 ТАХ-ий баримт бичгийн бүрдэл хангуулах, хянах, холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах зэрэг ажлууд хийгдэж байна.

Хүснэгт 15. Хөрөнгө бүртгэлийн нэгтгэл

№	Дүүргийн нэр	Хөрөнгөнд бүртгэх ТАХ		Бүртгэсэн ТАХ		Шууд зардалд тусгасан		Бүртгээгүй ТАХ		Зөрүү
		Тоо	Гэрээний дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн
1	БГД	63	23,307.9	49	10,931.3	14	11,531.8	-	-	844.8
2	БЗД	75	54,282.9	37	39,303.8	38	14,979.1	-	-	-
3	БНД	39	3,168.0	23	1,556.4	16	1,611.7	-	-	-
4	БХД	10	567.7	10	567.7	-	-	-	-	-
5	НД	27	882.5	17	708.9	9	143.6	1	30.0	-
6	СБД	134	49,172.5	87	36,678.8	47	12,493.6	-	-	-
7	СХД	60	18,738.4	43	9,427.6	16	7,658.3	1	1,200.0	452.6
8	ХУД	116	65,128.0	85	47,337.3	27	7,015.9	4	10,774.8	-
9	ЧД	54	8,012.6	31	6,817.6	22	1,117.1	1	77.8	-
НИЙТ		578	223,260.5	382	153,329.4	189	56,551.1	7	12,082.6	1,297.4

Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 56,551.1 сая төгрөгийн дүнтэй 189 ТАХ-г шууд зардлаар бүртгэсэн байна. Тухайлбал:

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16.6-д “Орон сууцны байшингийн ашиглалтын хугацаанд дундын өмчлөлийн эд хөрөнгөд хамаарах дээвэр, цахилгаан шат зэрэгт их засвар хийх үед их хэмжээний хөрөнгө шаардагдах бол барилгын хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн улсын болон орон нутгийн төсвөөс нэг удаа санхүүжүүлж болно” гэж заасныг үндэслэн 31,357.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 72 ТАХ-г шууд зардлаар бүртгэсэн байна.

Дүгнэлт: Ашиглалтад хүлээн авсан барилга байгууламж, тохижилт, дэд бүтэц, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийн 98.8 хувийг данс бүртгэлд тусгасан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй, магадлалын дүгнэлтгүй, хөрөнгө ашиглалттай холбоотой зардлын тооцоолол хийгээгүй зэрэг төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.
2. Зарим худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн баримт бичигт тусгасан шаардлагад нийцээгүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.
3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө оруулалтын зарим ажлууд чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байна.
4. Зарим ТАХ-ний гэрээнд заасан алдангийн хоногийг бүрэн тооцоогүй, урьдчилгаа төлбөрийг холбогдох журамд нийцүүлээгүй олгосон байна.
5. Ашиглалтад хүлээн авсан барилга байгууламж, тохижилт, дэд бүтэц, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийн 98.8 хувийг данс бүртгэлд тусгасан байна.
6. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлууд нь иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх, төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад тодорхой үр нөлөө үзүүлсэн байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Дүүргүүдийн ИТХ болон ЗД нарт:

1. Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан, төлөвлөлтийн хувьд алдаагүй, иргэдийн саналд үндэслэсэн төсөл арга хэмжээг төлөвлөж, батлуулах;
2. Төсөл арга хэмжээний төлөвлөлт, худалдан авалт, гүйцэтгэлийн үе шатанд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зөрчлийг таслан зогсоох, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх;

Дүүргүүдийн ЗДТГ болон Худалдан авах ажиллагааны албаны дарга нарт:

1. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан төсөл арга хэмжээг төлөвлөх;
2. Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль тогтоомжийн хүрээнд үнэлэн тендерийн баримт бичгийн шалгуурыг баримталж ажиллах, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;
3. Төсөл арга хэмжээг ашиглалтын шаардлага хангахуйц түвшинд гүйцэтгүүлэх, дутуу болон чанаргүй хийсэн ажлуудыг гүйцэтгэгчдээр дахин хийлгэх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;
4. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгох, гэрээний алдангийн хоногийг бүрэн тооцох, урьдчилгаа төлбөрийг журамд нийцүүлэн олгох;
5. Хөрөнгө оруулалтаар бий болсон ажлын ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, эзэнжүүлэх;
6. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх, өгсөн зөвлөмж, хүргүүлсэн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын биелэлтийг хугацаанд нь хэрэгжүүлж Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Замчдын гудамж 3, 27 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16052
Утас: (976) 7012 0320
Цахим шуудан: info@bgd.mn
Цахим хуудас: www.bgd.mn

2025.05.09 № 02/1213
танай 2025.05.05 -ны № 01/422 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Дүүргийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд тусгах саналгүй болно.

Хавсралт 1 хуудастай.



Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
Тамгын газрын дарга
Тамгын газрын дарга
Батболд МӨНГӨНХУЯГ
2025.05.09 14:56



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Нутгийн захиргааны нэгдсэн байр,
Баянголын гудамж 1, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 16082
Утас: (976) 7017 2216
Цахим хуудас: www.shd.mn

2025.05.13 № 01/1631
танай 2025.05.05 -ны № 01/422 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд аудитын тайлангийн төсөлд өгөх саналаа 10 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ" заасныг үндэслэн манай байгууллагын зүгээс өгөх "Саналгүй" болно.



Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг дарга
Цэдэндамба Баттөр
2025.05.13 16:01



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Энхтайвны өргөн чөлөө-57, 13 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13330
Утас/Факс: (976-51) 26 63 59
Цахим хуудас: www.bzd.ub.gov.mn

2025.05.09 № 02/1154
танай -ны № -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Баянзүрх дүүрэгт хэрэгжүүлсэн "Дүүргийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2024/06-11-ШТА-ГА) тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын дүгнэлттэй холбоотой санал байхгүй болно.



Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Дамдинбат Цэнд-Очир
2025.05.09 13:44



БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Д Нацагдоржийн талбай, Наран хороолол,
1 дүгээр хороо, Багануур дүүрэг,
Улаанбаатар хот, 12090
Утас/Факс: (976) 7021 0017, 7021 0330
Цахим шуудан: info@bnd.ub.gov.mn
Цахим хаяг: www.bnd.ub.gov.mn

2025.05.12 № 01/509
танай 2025.05.05 -ны № 01/422 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Цаашид илэрсэн зөрчлийг дахин гаргахгүй байхад анхааран ажиллах болно.



Багануур дүүргийн засаг даргын тамгын газар
Захиргаа
Багануур дүүргийн засаг дарга
Сумъяа Даваасүрэн
2025.05.12 09:25



**НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**


Д.Даваажавын гудамж, 2 дугаар хороо,
Налайх дүүрэг, Улаанбаатар хот 12790
Утас: (976) 7023 2252, 7023 2204
Цахим шуудан: nadubgov@webmail.com
Цахим хуудас: www.nad.ub.gov.mn

2025.05.09	№	04/1009
танай	2025.05.05	-ны № 01/422 -т

ГНИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

"Дүүргийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын дүгнэлттэй холбоотой санал байхгүй болно.



Налайх дүүргийн засаг даргын тамгын газар
Удирдлага
Тамгын газрын дарга
Гэлэгжамц Бат-Очир
2025.05.09 16:25



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**


Иргэдэд үйлчлэх төв байр,
Чинхэсийн өргөн чөлөө, 20 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042
Утас: (976) 7777 1965
Цахим шуудан: info@khanuul.mn
Цахим хуудас: www.khanuul.mn

2025.05.09	№	03/739
танай	2025.05.05	-ны № 01/422 -т

ГНИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Дүүргийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн тайлантай танилцсан.

Тайлангийн үр дүнтэй санал нийлж хүлээн зөвшөөрч байна. Цаашид алдаа зөрчлийг дахин гаргуулахгүй байхад анхааран ажиллах болно.



Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Заяабаатар Буянт
2025.05.09 16:51




**СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Денверийн гудамж 13, 11 дүгээр хороолол,
7 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14190, Утас: (976) 7007 0109
Цахим шуудан: info@sbd.gov.mn
Цахим хуудас: www.sbd.ub.gov.mn

2025.05.13	№	04/1196
танай	2025.05.05	-ны № 01/422 -т

ГНИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Дүүргийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах болно.



Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Өлзийшигч Энхбаяр
2025.05.13 14:29



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Өндөр толгой, 1 дүгээр хороо,
Багахангай дүүрэг, Улаанбаатар хот, 12330
Утас: (976) 7049 1011
Цахим хуудас: www.bagakhangai.ub.gov.mn

2025.05.12	№	04/393
танай	2025.05.05	-ны № 01/422 -т

ГНИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

"Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийгдсэн гүйцэтгэлийн аудитын /НТАГ-2024/06-11-ШТА-ГА/тайлангийн дүгнэлтэд саналгүй болно.



Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар
Удирдлага
Тамгын дарга
Лхагваа Санхйжамц
2025.05.12 15:29



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбүүгийн гудамж 16, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7777 1992
Цахим шуудан: info@chingeltei.gov.mn
Цахим хуудас: www.chingeltei.gov.mn

2025.05.12 № 03/1371
танай _____ -ны № _____ -г

「НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ」

“Дүүргийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2024/06-11-ШТА-ГА) тайлантай танилцлаа.

Тусгайлан саналгүй болно.



Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Оросоо Батмөнх
2025.05.13 11:11

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Дүүргүүдийн ЗД болон ЗДТГ-аас аудитын тайлангийн төсөлтэй танилцаж Төрийн аудитын тухай хуулийн 18.2-д заасан хуулийн хугацаанд саналаа ирүүлж, цаашид аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллахаа илэрхийлсэн.

ХАВСРАЛТ

Хавсралт 1

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлээгүй ТАХ

(сая.төг)

№	Дүүргийн нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилжих	Төсөвт өртөг	Хугацаа	
						Эхлэх	Дуусах
1	БЗД	Прокурорын газрын засварын ажил	Их засвар	Шинэ	327.2	2024	2025
2	БЗД	Татварын хэлтсийн засварын ажил	Их засвар	Шинэ	297.0	2024	2025
3	БЗД	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн засварын ажил	Их засвар	Шинэ	150.0	2024	2025
4	БЗД	Барилгын засварын ажил	Их засвар	Шинэ	171.8	2024	2025
5	БЗД	Нийтийн зээмшлийн орон сууцны цахилгаан шат шинэчлэлтийн ажил (Баянзүрх дүүрэг, 6 дугаар хороо, 23 дугаар байр)	Их засвар	Шинэ	168.5	2024	2025
6	БЗД	Онцгой байдлын хэлтсийн гадна фасад засварын ажил	Их засвар	Шинэ	305.2	2024	2025
7	БЗД	Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	998.9	2024	2025
8	БЗД	Онцгой байдлын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	631.5	2024	2025
9	БЗД	Улсын бүртгэлийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	745.1	2024	2025
10	БЗД	Татварын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	48.7	2024	2025
11	БЗД	Харьяа газар, хэлтэс, албадад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	1,473.8	2024	2025
12	БЗД	Цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	1,328.0	2024	2025
13	БЗД	Албан бус насан туршийн боловсролын төвд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	38.0	2024	2025
14	БЗД	Замын цагдаагийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	379.2	2024	2025
15	БЗД	Баянзүрх Эко тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ, Олон Улсын эко цэцэрлэгт хүрээлэн ААТҮГ болон бусад хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	1,840.4	2024	2025
16	БЗД	Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй эмнэлгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	925.1	2024	2025
17	БЗД	Баянзүрх дүүргийн хэмжээнд үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах, нөхцөл байдлыг тодорхойлох зөвлөх үйлчилгээний ажил	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	200.0	2024	2025
18	БНД	Хүүхдийн зусланд ариун цэврийн байгууламж	Барилга байгууламж	Шинэ	250.0	2024	2024
19	БНД	4-р хорооны барилгын гадна фасад засвар, Иргэдэд үйлчлэх нэг цэгийн дотор засварын ажил	Их засвар	Шинэ	124.1	2024	2024
20	БНД	ОЭЦС-ийн 1-р байрны дээврийн засварын ажил	Их засвар	Шинэ	233.8	2024	2024
21	БНД	193 цэцэрлэгийн барилгын гадна дулаан, ус хангамжийн шугамын засварын ажил	Их засвар	Шинэ	140.4	2024	2024
22	БНД	Уурхайн нийтийн байрны барилгын гадна дулаан, ус хангамжийн шугамын засварын ажил	Их засвар	Шинэ	114.7	2024	2024
23	БНД	Баялаг хорооллын авто замын ажил	Авто зам, дэд бүтэц	Шинэ	810.5	2024	2024
24	БНД	ОЭЦС-ийн хичээлийн 2-р байрны дээврийн засварын ажил	Их засвар	Шинэ	116.6	2024	2024
25	БНД	3-р хороо Хилчин хэсгийн тохижилт	Тохижилт	Шинэ	457.0	2024	2024
26	БНД	Багануур-Ус ААТҮГ-т гэмтэл тодорхойлох багаж тоног төхөөрөмж худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	75.0	2024	2024
27	БНД	Дотоодын цэргийн тусгай салбарын албан хэрэгцээнд авто машин худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	80.0	2024	2024
28	БНД	Хүүхдийн зуслангийн гадна талбайн тоглоом худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	20.0	2024	2024
29	БНД	Киоск машин 2ш худалдан авах /УБХ, 3-р хороо/	Тоног төхөөрөмж	Шинэ	13.0	2024	2024
30	БНД	Наадмын талбайн 250 кВт КТП тоног төхөөрөмж худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	50.0	2024	2024

31	БНД	Хүүхдийн зусланд хөгжим аппаратур худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	20.0	2024	2024
32	БНД	Нийтийн тээврийн автобусын зорчигч тоологч камер /4ш/, байршил илрүүлэгч СР8, тээврийн хэрэгсэл цэвэрлэх, ариутгах тоног төхөөрөмж худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	19.1	2024	2024
33	БНД	Тэрбум мод төслийн хүрээнд хашаажуулах хашааны материал худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	75.0	2024	2024
34	БНД	Теле камерын хяналтын дэд төвд шаардлагатай бараа материал худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	35.1	2024	2024
35	БНД	Лифт засварт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	118.0	2024	2024
36	БНД	БТСХ-нд техник тоног төхөөрөмж худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	50.0	2024	2024
37	БНД	Төрийн байгууллагуудад компьютер тоног төхөөрөмж худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	142.0	2024	2024
38	БНД	Спорт хороонд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	200.0	2024	2024
39	БНД	БЦС-ийн хичээлийн 2-р байрны барилгын өргөтгөлийн зураг төсөв боловсруулах	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	143.4	2024	2024
40	БНД	УСБТ-н барилгын засварын зураг төсөв боловсруулах	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	90.0	2024	2024
41	БНД	ОБХ-ийн барилга байгууламжийн гадна болон дотор инженерийн шугам сүлжээг засварлах зураг төсөв боловсруулах	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	20.0	2024	2024
42	БНД	ХЦА-д спорт цогцолборын барилгын зураг төсөв боловсруулах	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	20.0	2024	2024
43	БНД	4,5 хорооны цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсөв боловсруулах	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	50.0	2024	2024
44	БНД	Спорт соёл амралтын цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтийн зураг төсөв боловсруулах	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	70.0	2024	2024
45	БНД	Биеийн тамир спорт хорооны засварын зураг төсөв шинэчлэх	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	11.0	2024	2024
46	БНД	132 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын холболтын зураг төсөв боловсруулах	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	50.0	2024	2024
47	СХД	Гараашны барилга худалдаж авах (Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ)	Барилга байгууламж	Шинэ	1,384.0	2024	2024
48	СХД	Тоног төхөөрөмж (Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ)	Тоног төхөөрөмж	Шинэ	200.0	2024	2024
49	СХД	Барилгын 1 дүгээр давхрын үүдний хэсэг, хонгилын интерьерийн угсралтын ажил (Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх)	тохижилт	Шинэ	76.3	2024	2024
50	СХД	Спорт заалны засварын ажил (Цагдаагийн нэгдүгээр хэлтэс)	Их засвар	Шинэ	379.4	2024	2024
51	СХД	Дээврийн засвар (Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн байр)	Их засвар	Шинэ	157.4	2024	2024
52	СХД	Дээвэр, фасад засвар (Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн байр)	Их засвар	Шинэ	118.3	2024	2024
53	СХД	Тавилга, тоног төхөөрөмж (Татварын хэлтэс)	Тоног төхөөрөмж	Шинэ	288.4	2024	2024
54	СХД	Гарааш барих (ТЦҮ ОНӨААТҮГ)	Барилга байгууламж	Шинэ	3,000.0	2024	2024
55	СХД	Татварын хэлтсийн байрны гадна бохирын ажил	Авто зам, дэд бүтэц	Шинэ	203.5	2024	2024
56	СХД	Амралт цогцолборын газарт гэр худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	70.0	2024	2024
57	СХД	Газар чөлөөлөлт	бусад	Шинэ	3,649.8	2024	2024
58	СХД	Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Спорт заалны дээврийн засварын ажил	Их засвар	Шинэ	120.8	2024	2024
59	СХД	Материал худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	20.0	2024	2024
60	СХД	Мэдүүлэг авах өрөөний засвар	Их засвар	Шинэ	127.0	2024	2024
61	СХД	Зураг, төсөв боловсруулах зардал	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	1,406.0	2024	2024
62	ХУД	Яармаг худалдааны төвийн барилгыг төвийн шугам сүлжээнд холбох ажил (5 дугаар хороо)	Авто зам, дэд бүтэц	Шинэ	280.0	2024	2024
63	ХУД	72 дугаар цэцэрлэгийн хашаа (2 дугаар хороо)	Тохижилт	Шинэ	80.0	2024	2024
НИЙТ					25,188.2		

**ДЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд
нийцүүлээгүй ТАХ**

(сая.төг)

№	Дүүргийн нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилжих	Төсөвт өртөг	Хугацаа	
						Эхлэх	Дуусах
1	БЗД	Прокурорын газрын засварын ажил	Их засвар	Шинэ	327.18	2024	2025
2	БЗД	Татварын хэлтсийн засварын ажил	Их засвар	Шинэ	297.00	2024	2025
3	БЗД	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн засварын ажил	Их засвар	Шинэ	150.00	2024	2025
4	БЗД	Онцгой байдлын хэлтсийн гадна фасад засварын ажил	Их засвар	Шинэ	305.22	2024	2025
5	БЗД	Баянзүрх дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	990.00	2024	2025
6	БЗД	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	1,145.94	2024	2025
7	БЗД	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад шаардлагатай гал тогооны үндсэн ба туслах тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	594.59	2024	2025
8	БЗД	Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	998.93	2024	2025
9	БЗД	Онцгой байдлын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	631.49	2024	2025
10	БЗД	Улсын бүртгэлийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	745.14	2024	2025
11	БЗД	Татварын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	48.73	2024	2025
12	БЗД	Баянзүрх дүүргийн харьяа газар, хэлтэс, албадад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	1,473.81	2024	2025
13	БЗД	Цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	1,328.00	2024	2025
14	БЗД	Монгол тэмүүлэл сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	99.40	2024	2025
15	БЗД	Албан бус насан туршийн боловсролын төвд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	37.98	2024	2025
16	БЗД	Замын цагдаагийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	379.17	2024	2025
17	БЗД	Баянзүрх Эко тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ, Олон Улсын эко цэцэрлэгт хүрээлэн ААТҮГ-азруудад болон бусад хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	1,840.41	2024	2025
18	БЗД	Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй эмнэлгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	Тоног төхөөрөмж	Шинэ	925.15	2024	2025
19	БНД	Нийтийн тээвэрт дунд оврын авто машин худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	140.00	2024	2024
20	БНД	Дотоодын цэргийн тусгай салбарын албан хэрэгцээнд авто машин худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	80.00	2024	2024
21	БНД	Теле камерын хяналтын дэд төвд шаардлагатай бараа материал худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	35.07	2024	2024
22	БНД	Спорт соёл амралтын цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтийн зураг төсөв боловсруулах	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	70.00	2024	2024
23	СХД	Орон сууцны байрны лифт засвар, шинэчлэл	Их засвар	Шинэ	205.65	2024	2024
24	СХД	Орон сууцны байрны лифт шинэчлэл	Их засвар	Шинэ	560.00	2024	2024
25	СХД	Орон сууцны байрны лифт шинэчлэл	Их засвар	Шинэ	270.00	2024	2024
26	СХД	Гараашийн барилга худалдаж авах (Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ)	Барилга байгууламж	Шинэ	1,384.00	2024	2024
27	СХД	Барилгын 1 дүгээр давхрын үүдний хэсэг, хонгилын интерьерийн угсралтын ажил (Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх)	тохижилт	Шинэ	76.34	2024	2024
28	СХД	Спорт заалны засварын ажил (Цагдаагийн нэгдүгээр хэлтэс)	Их засвар	Шинэ	379.38	2024	2024

29	СХД	Дээврийн засвар (Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн байр)	Их засвар	Шинэ	157.38	2024	2024
30	СХД	Дээвэр, фасад засвар (Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн байр)	Их засвар	Шинэ	118.31	2024	2024
31	СХД	Тавилга, тоног төхөөрөмж (Татварын хэлтэс)	Тоног төхөөрөмж	Шинэ	288.40	2024	2024
32	СХД	Гарааш барих (ТЦҮ ОНӨААТҮГ)	Барилга байгууламж	Шинэ	3,000.00	2024	2024
33	СХД	Татварын хэлтсийн байрны гадна бохирын ажил	Авто зам, дэд бүтэц	Шинэ	203.52	2024	2024
34	СХД	Амралт цогцолборын газарт гэр худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	70.00	2024	2024
35	СХД	Газар чөлөөлөлт	бусад	Шинэ	3,649.80	2024	2024
36	СХД	Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Спорт заалны дээврийн засварын ажил	Их засвар	Шинэ	120.77	2024	2024
37	СХД	Материал худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	19.96	2024	2024
38	СХД	Мэдүүлэг авах өрөөний засвар	Их засвар	Шинэ	127.00	2024	2024
39	СХД	Зураг, төсөв боловсруулах зардал	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	Шинэ	1,405.99	2024	2024
40	ХУД	Гал унтраах, аврах 14 дүгээр ангийн барилгын их засварын ажил	Их засвар	Шинэ	288.00	2024	2024
41	ХУД	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засварын ажил	Их засвар	Шинэ	923.60	2024	2024
42	ХУД	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан засварын ажил	Их засвар	Шинэ	55.00	2024	2024
43	ХУД	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засварын ажил (3, 15 дугаар хороо)	Их засвар	Шинэ	500.00	2024	2025
НИЙТ					26,446.29		

Хавсралт 3

Холбогдох зардлын тооцоолол хийгээгүй ТАХ

(сая.төг)

№	Дүүргийн нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилжих	Төсөвт өртөг	Хугацаа	
						Эхлэх	Дуусах
1	БЗД	Жишиг хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажил	Барилга байгууламж	Шинэ	2,902.3	2024	2025
2	БЗД	64 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 11 дүгээр хороо)	Барилга байгууламж	Шинэ	1,882.1	2024	2025
